



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А-335

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын шагналын журмыг нэгдүгээр, шагнуулах хүний анкетын загварыг хоёрдугаар, шагналын үнэмлэх, тэмдгийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, дагалдах үнэмлэх, яамны жуух бичгийн нөөцийг сайдын жил бүрийн төсвийн багцад тусгуулахыг Санхүүгийн хэлтсийн дарга /Ш.Эрдэнэцэцэг/-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Г.Батбаяр/-д даалгасугай.

4.Энэ журам гарсантай холбогдуулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт онцгой амжилт гаргасан, мэргэжлээрээ тогтвортой, үр бүтээлтэй ажилласан Монгол Улсын болон гадаад улсын иргэн /цаашид "нэр дэвшигч" гэх/-ийг Засгийн газрын шагнал болон яамны шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Шагналын төрөл

2.1."Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, яамны шагнал нь дор дурдсан төрөлтэй байна. Үүнд:

2.1.1. "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг:

- 2.1.1.1 Тэргүүний уурхайчин;
- 2.1.1.2 Тэргүүний геологич;
- 2.1.1.3 Газрын тосны тэргүүний ажилтан;
- 2.1.1.4 Үйлдвэрийн тэргүүний ажилтан;

2.1.2. Яамны шагнал:

- 2.1.2.1 Яамны жуух бичиг;
- 2.1.2.2 Салбарын түүхэн ойн хүндэт медаль.

Гурав. Шагнал олгох болзол

3.1.Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт тухайн мэргэжлээрээ 12-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, амжилт бүтээл нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэшлийн өндөр ур чадвартай нэр дэвшигчийг "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр шагнана.

3.2.Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт 7-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээл, санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ тэргүүлсэн, салбарыг хөгжүүлэх үйлсэд амжилт гаргасан нэр дэвшигчийг яамны "Жуух бичиг"-ээр шагнана.

3.3.Тухайн салбарын түүхэн ойг тохиолдуулан 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан болон онцгой амжилт гаргасан нэр дэвшигчийг салбарын түүхэн ойн "Хүндэт медаль"-аар шагнана.

3.4.Дор дурдсан шалгуурыг харгалзан шагналд нэр дэвшүүлнэ:

3.4.1.Ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, ажил үйлчилгээг хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн чанартай, шуурхай гүйцэтгэж, эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, мэргэжлийн өндөр ур чадвар

гарган идэвх, санаачилгатай ажиллаж байгаа ажилчин, албан хаагч;

3.4.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургахад бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэн, судлаач;

3.4.3. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, холбоо, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмад ажилтан, гадаадын иргэн;

3.4.4. Салбарын үйл ажиллагаанд онцгой үр дүн өгөхүйц нээлт шинэ бүтээл, оновчтой санал гаргасан, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой дэвшилтэт шинэ техник, технологийг нэвтрүүлсэн иргэн;

3.4.5. Үйлдвэрлэлд учирч болох хөдөлмөр хамгааллын зөрчил болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирол, хор уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, албан хаагчид тус тус олгож болно.

3.5. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг олгохдоо тухайн нэр дэвшигчийн эзэмшсэн мэргэжлийн дагуу журмын 2.1.1-т заасан хүндэт тэмдгээс аль тохирох төрлийн тэмдгийг олгоно.

3.6. Журмын 3.5-д заасны дагуу “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнагдсан этгээдэд журмын 2.1.1-т заасан хүндэт тэмдгийн бусад төрлөөс дахин олгохгүй.

3.7. Журмын 3.4.3, 3.4.4, 3.4.5 дахь хэсэгт заасан үзүүлэлтээр онцгой амжилт гаргасан тохиолдолд “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг” болон “Салбарын түүхэн ойн хүндэт медаль”-аар хугацаанаас нь өмнө буюу алгасуулан шагнаж болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргах ба шагнуулах үндэслэл, амжилтыг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Мөн нэр дэвшигчийг хамт олны хурлаар хэлэлцэн, шагнуулах асуудлаар тэмдэглэл үйлдэж хавсарган ирүүлсэн байна.

4.2. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг” болон “Салбарын түүхэн ойн хүндэт медаль”-аар шагнуулах хүсэлтийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр сүүлийн 5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргана.

4.3. Шагналд нэр дэвшүүлэхдээ дор дурдсан материалыг бүрдүүлнэ. Үүнд:

4.3.1. шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг;

4.3.2. батлагдсан загварын анкет /цээж зураг 3x4/;

4.3.3. байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл;

4.3.4. ажил байдлын тодорхойлолт /байгууллагын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулах/;

4.3.5. өмнө нь шагнагдсан талаарх баримт бичиг /төрийн одон, медаль, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, жуух бичгийн хуулбарыг хавсаргах/;

4.3.6. онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, нотолгооны хуулбар;

4.3.7. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр болон ажилд орсон, гарсан тушаалын бичилт бүхий хуудас орно/ болон Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт.

4.4. Шагналд нэр дэвшигчийн баримт бичгийг сайдын шийдвэр батлагдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө яаманд цаасан хэлбэрээр ирүүлнэ.

4.5. Нэр дэвшигчийн баримт бичгийг хугацаа хожимдуулсан, дутуу болон хуурамчаар бүрдүүлсэн, энэхүү журмын 3 дахь заалтыг хангаагүй тохиолдолд шагнал олгох асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд холбогдох материалыг илгээсэн байгууллагад нь буцааж, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн буруутай албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэнэ.

4.6. Яамны харьяа агентлаг, байгууллага шагналын материалыг энэхүү журмын 4.3, 4.4-т заасан шаардлагыг ханган албан бичгээр ирүүлнэ.

4.7. Энэхүү журмын 3.1, 3.4-т заасан болзлыг хангаж, өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс ахисан нөхцөлд дараагийн шагналд нэр дэвшүүлэх эрх нээгдэнэ.

4.7. Сонгуульт болон нам, олон нийтийн байгууллага, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь гишүүд, идэвхтнээ шагнуулах саналыг тухайн ажиллаж байсан үндсэн байгууллагад нь гаргах ба зөвхөн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тодорхойлолт, албан бичгийг хүлээж авна.

4.8. Тухайн салбарт удаан жил ажилласан ахмад ажилтан, ажилчдыг яам, харьяа агентлаг, орон нутгийн удирдлагын саналыг үндэслэн сайдын шийдвэрээр олгоно.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Шагналд нэр дэвшигчийн бичиг баримтыг тус яамны шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч, энэхүү журмын 4.3-т заасан бичиг баримтыг хянан, бүрдлийг хангуулж, холбогдох саналаа удирдлагад танилцуулна.

5.2. Шагнах асуудлыг салбарын сайдын шийдвэрээр дор дурдсан баярын өдрүүдэд энэхүү журмын 3.1, 3.2, 3.4-т заасан шаардлага хангасан нэр дэвшигчдэд олгоно:

5.2.1. Үндэсний их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр;

5.2.2. Салбарын ойн баярын өдөр буюу Геологичдын өдөр, Уурхайчдын өдөр, Газрын тосны салбарын ажилтны өдөр болон Хүнд үйлдвэрийн баярын өдөр /зөвхөн тухайн салбарт мэргэжлээрээ ажилласан, журмын 3.1, 3.2, 3.4-т тавигдсан шалгуурыг хангасан нэр дэвшигч/;

5.2.3. Сайдын зөвшөөрснөөр геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа томоохон аж ахуйн нэгж, байгууллагын тэгш ойн баярын өдрөөр тус тус олгоно.

5.3. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон дугаар бүхий үнэмлэх, гэрчилгээний хамт олгогдох бөгөөд үнэмлэх, хүндэт тэмдгийг яамнаас олгоно.

5.4. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух

бичиг"-ийг дагалдах мөнгөн шагналыг тухайн нэр дэвшигчийг шагналд тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

5.5.Салбарын тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд нөхөн олгож болно. Нөхөн олгоход дараах материалыг бүрдүүлнэ.

5.5.1.Нөхөн олгож өгөхийг хүссэн өргөдөл;

5.5.2.Өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр үрэгдүүлсэн тухай зарлуулсан баримт;

5.6.Энэхүү журмын 5.5-д заасан өргөдөл, баримтыг үндэслэн шагналыг нөхөн олгоход гарсан зардлыг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулна.

Зургаа. Шагналын мэдээллийн сан

6.1.Яам нь шагнагдсан хүмүүсийн мэдээллийг шагналын төрөл, огноогоор төрөлжүүлэн цахим сан бүрдүүлж ажиллана.

6.2.Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг тус яамны шагнал, урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан хөтөлж, хяналт тавина.

6.3.Яамнаас шагналын талаарх лавлагаа, мэдээлэл авч болно.

Долоо. Бусад

7.1.Яамны албан хаагчид болон харьяа агентлаг байгууллагаас төрийн дээд цол, одон, медаль, хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолтыг судлан салбарын сайд болон Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-д заасны дагуу нэр дэвшүүлэн, өргөн мэдүүлнэ.

---oOo---

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны 35 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

"САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"
ТЭМДГЭЭР ШАГНУУЛАХ ХҮНИЙ АНКЕТ

Зураг

1. Ургийн овог
2. Эцэг/эхийн/ нэр
3. Нэр.....
4. Хүйс.....
5. Төрсөн он, сар, өдөр.....
6. Регистрийн дугаар.....
7. Боловсрол, мэргэжил.....
8. Үндсэн захиргаа
9. Одоогийн харьяалал
10. Ажилладаг салбар
11. Ажилласан хугацаа: Нийт..... жил, үүнээс тухайн салбарт жил, тухайн хамт олны дотор жил
12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил

13. Урьд шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Шагнагдсан он


14. Шагнуулах үндэслэл: Үүнд: тухайн хүний гаргасан ажлын амжилт, санаачилга, түүний үр дүн, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологи, санал санаачилга, бүтээл туурвил зэргийг сүүлийн 3 жилээр тусгана. /Ажлын үзүүлэлт, холбогдох тооцоог хавсаргана/

15. Хамт олны санал:

16. Ямар шалтгаанаар шагнуулах:

байгууллагын даргын гарын үсэг

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны 33 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

..... Таныг



Дугаар ...

20 ... он ... сарын ...

Геологийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасныг тань үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 20 ... оны ... дугаар тушаалаар Монгол Улсын "ТЭРГҮҮНИЙ ГЕОЛОГИЧ" тэмдгээр шагнаж, үнэмлэх олгов.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Г.БИНДОН

A large, stylized handwritten signature in black ink, written over a horizontal line.

ҮНЭМЛЭХ

..... Танаа



Дугаар ...

20 ... он ... сарын ...

Хүнд үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасныг тань үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар "ҮЙЛДВЭРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН" хүндэт тэмдгээр шагнаж үнэмлэх олгов.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Г.БИНДОН

A large, stylized handwritten signature in black ink, written over a horizontal line.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



Дугаар . . .

20 ... он ... сарын

..... Таныг

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасныг тань үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 20 ... оны ... дугаар тушаалаар **"ТЭРГҮҮНИЙ УУРХАЙЧИН"** тэмдгээр шагнаж, үнэмлэх олгов.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Г.ЁНДОН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



Дугаар . . .

20 он сарын

..... Таныг

Газрын тосны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасныг тань үнэлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 20 ... оны ... дугаар тушаалаар **"ГАЗРЫН ТОСНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"** тэмдгээр шагнаж, үнэмлэх олгов.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Г.ЁНДОН